БАТЛАВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ДЭРГЭДЭХ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА О.ЭРДЭНЭСАМБУУ



ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ

2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа /улирлаар/	Хариуцах албан тушаалтан
	Нэг. Ерөнхий		
1.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах	Жилдээ	Нийт гишүүд
2.	Хариуцсан салбар, байгууллага, нэгж дотроо судалгаа хийх, гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулах	Жилдээ	Нийт гишүүд
3.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх	Улирал бүр	Нарийн бичгийн дарга
4.	Дипломат ажилтны сахилгын тусгай дүрмийг Төрийн албаны ёс зүйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлж, шинэчлэн батлуулахад дэмжлэг үзүүлэх	I хагас	Нийт гишүүд
	Хоёр. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх		
5.	ГХЯ-ны хэмжээнд 2025 оныг ёс зүй, сахилга хариуцлагын жил болгон зарлаж, яамны нийт ажилтнуудад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн хууль тогтоомжийг таниулах сургалтыг зохион байгуулах	Улиралд нэг удаа	О.Цэцэгмаа Т.Эрдэнийнчулуу П.Сүхбаатар
6.	ГХЯ-нд шинээр ажилд орсон ажилтнууд болон шинээр ДТГ-т томилогдсон ажилтнуудад чиглүүлэх сургалтыг зохион байгуулах	Тухай бүр	Нийт гишүүд
	Гурав. Өргөдөл, гомдол		
7.	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, өргөдөл, гомдлын бүртгэлийг нягт хөтөлж, дэд хорооны гишүүдэд тухай бүр нь шуурхай танилцуулах	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
8.	Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл, өргөдөл, гомдлыг тухай бүр нь холбогдох журмын дагуу Ёс зүйн дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, шуурхай арга хэмжээг авах	Тухай бүр	Нийт гишүүд

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 15-ны өдрийн 9 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]

Гадаад харилцааны яам ажилтандаа ээлтэй, ажиллахад таатай, сахилга, хариуцлагатай дипломат албыг бэхжүүлэх зорилтын хүрээнд тус албаны хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, "Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм"-д тусгасан ёс зүй, сахилгын хэм хэмжээг сахиулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхааран ажиллаж, 2025 оныг "Сахилга, хариуцлагын жил" болгон зарласан. Энэ хүрээнд Дипломат албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг удирдлага болгон ажиллав.

Энэ онд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд соён гэгээрүүлэх ажилд ихээхэн ач холбогдол өгч Гадаад харилцааны яам болон хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын албан хаагчдад зориулан нийт 6 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулав.

Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх тандах судалгаанд нийт 201 албан хаагч, үйлчилгээ авч буй 6 иргэн хамрагдав.

Мөн Ёс зүйн дэд хороо нь Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудас"-ыг Гадаад харилцааны яам болон хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын нийт албан хаагчдаар бөглүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Түүнчлэн, Ёс зүйн дэд хорооны дарга О.Эрдэнэсамбуу Төрийн албаны зөвлөлөөс 2025 оны 7 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулсан Төрийн албан хаагчдын үндэсний чуулганд панелистаар оролцон Ёс зүйн тухай хуулийг сайжруулах талаарх саналаа танилцуулав. Мөн Төрийн албаны зөвлөлөөс 11 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулсан "Ёс зүйн төлөв байдал, эрсдэлийн үнэлгээний арга зүйн асуудал" сэдэвт "7:4:10" цахим мэдээллийн цагийн хөтөлбөр, Монгол Улсын Ёс зүйн хорооноос 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан "Төрийн албан дахь ёс зүйн төлөв байдлыг тандах судалгаа, зарим төрийн байгууллагад хийсэн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний танилцуулга, хэлэлцүүлэг"-т тус тус оролцов.

Дэд хороонд 2025 онд нийт 4 гомдол ирсэн бөгөөд үүний 3 нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох гомдол биш байсан учир гомдол гаргагчдад холбогдох хариуг өгсөн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8.1 болон 8.2-т заасан ёс зүйн нийтлэг шаардлагад хамаарах 1 гомдол ирснийг хэлэлцэж, дүгнэлт гаргасан. Мөн өмнөх оны 12 дугаар сард ирсэн гомдлыг хэлэлцэн холбогдох дүгнэлтийг гаргасан болно.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

---

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэв:

1. Сургалт

- Тус яамны газар нэгжийн удирдлагуудад зориулан "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн бодлого, хэрэгжилт" сэдвээр 2 дугаар сарын 20-ны өдөр,
- Шинээр томилогдон ажиллаж буй албан хаагчдад зориулан "Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх зохицуулалт, бүтэц" сэдвээр 5 дугаар сарын 15-ны өдөр,
- Хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт ажиллахаар томилогдсон албан хаагчдад зориулан "Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх зохицуулалт, бүтэц" сэдвээр 6 дугаар сарын 3-ны өдөр,
- Хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт ажиллахаар томилогдсон албан хаагчдад зориулан "Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх зохицуулалт, бүтэц" сэдвээр 8 дугаар сарын 27-ны өдөр,
- Нийт албан хаагчдад зориулан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, хэрэгжилт" сэдвээр 9 дүгээр сарын 9-ний өдөр,
- Хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын нийт албан хаагчдад зориулан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомж, хуулийн хэрэглээ" сэдвээр 11 дүгээр сарын 6-ны өдөр тус тус сургалт зохион байгуулав.

Нийт 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 400 гаруй албан хаагч хамрагдсан.

Мөн түүнчлэн Ёс зүйн дэд хорооны дарга О.Эрдэнэсамбуу шинээр томилогдсон Кызыл хот дахь Ерөнхий Консул О.Цэндсүрэн, Хонконг дахь Ерөнхий Консулын Д.Одбаяр, Эрээн хот дахь Консул З.Лхагвадорж, Пусан хот дахь Консул Ц.Жадамбаа, Манжуур хот дахь Консул Г.Золзаяа зэрэг ДТГ-ын удирдах албан тушаалтнуудыг хүлээн авч уулзан Ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт, хэрэг хянан шийдвэрлэх процесс болон ДТГ-т гарч буй Ёс зүйн асуудлуудын талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав.

2. Ёс зүйн нөлөөллийн үнэлгээ

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2025 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээний хуудас"-ыг Гадаад харилцааны яам болон хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын нийт албан хаагчдаар бөглүүлэх ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд 2026 оны 1 дүгээр сард багтаан дуусгахаар ажиллаж байна.

3. Ёс зүйн зөрчлийн талаарх тандах судалгаа

Монгол Улсын Ёс зүйн хорооноос "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд зохион байгуулсан төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх тандах судалгаанд Гадаад харилцааны яам, Дипломат төлөөлөгчийн газрын нийт 201 албан хаагч хамрагдсан.

Мөн Консулын газрын иргэдэд үйлчлэх хэсэгт иргэдээс авах судалгааны QR кодыг хэвлэн байршуулж, судалгаанд хамрагдахыг уриалж ажилласан бөгөөд нийт 6 иргэн хамрагдсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг нь нийт ГХЯ-ны системд ёс зүйн манлайллыг үзүүлэн ажиллан байгаа бөгөөд тус яамыг ажилтандаа ээлтэй, ажиллахад таатай, ёс зүйтэй, сахилга, хариуцлагатай дипломат албыг бэхжүүлэх зорилтыг дэвшүүлэн ёс зүйн тухай хууль, соён гэгээрүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлд Ёс зүйн дэд хороог дэмжин нягт хамтран ажиллаж байгаа болно. Тэрээр 2025 оны эхэнд нийт Дипломат төлөөлөгчийн газарт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд ёс зүйн байдлыг сайжруулах тухай зааварлах захидлыг хүргүүлсэн.

---

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:	
Тус яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо 7 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнд удирдах албан тушаалтан, ахмад дипломатч, консул, эрх зүй, хүний нөөцийн чиглэлийн албан тушаалтан, залуу ажилтны төлөөллийг багтаасан. Бие даасан, хараат бусаар ажиллаж байна. Дэд хороонд зарим сул орон тоо гарсантай холбогдуулан нийт албан хаагчдын дунд санал асуулга явуулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/382 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Дэд хороо нь "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-т нийцүүлэн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ажиллав.	
Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Нийт албан хаагчдад соён гэгээрүүлэх сургалт, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаар тогтмол мэдээлэл өгч ажилласнаар ёс зүйн зөрчлийн талаар суурь мэдээлэл, нийтлэг ойлголттой болсон. 2025 онд ГХЯ-ны төв аппаратын хэмжээнд ёс зүйн зөрчил гараагүй, нийт ДТГ-дад ёс зүйн зөрчлийн тоо багассан эерэг үр дүн гарсан.	Тус яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд ахмад дипломатч багтдаг хэдий ч өдгөө ажиллаж буй албан тушаалтан биш учир Төрийн албаны "ХНУМТ" цахим системд гишүүнээр бүртгүүлэх боломжгүй байна. Мөн хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй албан хаагчтай холбогдох ёс зүйн зөрчлийн гомдол ирсэн тохиолдолд уг системд бүртгэх боломжгүй байна.
Санал:	
- Төрийн албаны "ХНУМТ" цахим системийг илүү боловсронгуй болгох саналтай.	

Шалгах хэсэг:

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан,
Төрийн нарийн бичгийн дарга _____ Л.Мөнхтүшиг
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга,
Консулын газрын зөвлөх _____ О.Эрдэнэсамбуу
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга,
Европ, Африкийн газрын
атташе _____ Э.Тунгалаг
/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2026 оны 01 дүгээр сарын 5

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0,8	8
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0,4	4
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0,5	5
Хэсгийн оноо				**4**	3.7	37
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн мэдлэйлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хүчийн жинхэзр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0.25	2.5
Хэсгийн оноо				**3**	2.25	22.5
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хүчийн жинхэзр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	3	30
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8.95**	**89.5**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:
[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлалсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлалсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлалсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-